

1930-аад ОНЫ ЗӨВЛӨЛТ ХОЛБООТ УЛСЫН АЛС ДОРНОДЫН БОДЛОГО ДАХЬ МОНГОЛЫН ТУСГААР ТОГТНОЛЫН АСУУДАЛ

1920-иад оны эцэс 1930-аад оны эхнээс ЗХУ-ын Алс Дорнодын бодлогод дэлхийн дайны аюултай холбогдон цэрэг стратегийн чиглэл тэргүүлэх байранд тавигдах болсны адил Монголын тусгаар тогтнолын асуудалд ч энэ үүднээс хандах шаардлагатай болжээ. Дэлхий дахинд фашизм, дайны аюул өсөж, эдийн засгийн хямрал, Уналт үргэлжилж, дэлхийг дахин хуваах гэсэн их гүрнүүдийн өрсөлдөөн ширүүсч байсан 1930-аад оны эхэн үед Алс Дорнодод түгшүүртэй байдлыг даамжируулсан үйл явдал нэн хурдтай өрнөж байв. 1931 оны есдүгээр сард Японы цэрэг Зүүн хойт Хятадад халдан довтолж 1932 оны эхэн гэхэд Манжуурыг бүрэн эзлээд Манж-го хэмээгч тоглоомын улсыг байгуулан түүнийг түрэмгийллээ цаашид өрнүүлэх түшиц газар болгожээ. Удалгүй японы милитаристууд Зүүн хойт Хятадын бусад нутаг, Өвөр Монголын ихэнх хэсгийг эзлэн ЗХУ ба БНМАУ-ын хил хязгаарт шууд тулж ирсэн юм. Ийнхүү Япон нь бүхнээс түрүүнд түрэмгийллийн замд орсноор Алс Дорнодод дайны голомт үүсчээ.

Японы милитаристууд Хятадад түрэмгийллээ өргөтгөхийн зэрэгцээ ЗХУ ба БНМАУ-ын хил хязгаарт өнгөлзөн, хилийн дагуу цэрэг, эдийн засгийн түшиц, зам, цэргийн бэхлэлт байгуулах зэргээр түрэмгийлэлд илэрхий бэлтгэж байв. Японы дайны ажиллагаа, ялангуяа Хятадын нутгийг эзлэн авсан явдлыг эсэргүүцэж, Хятадаас савраа тат гэдэг уриан дор дэлхийн олон нийтийн хүчирхэг хөдөлгөөн өрнөжээ. Чухал энэхүү хөдөлгөөн, тэмцлийн явцад улс орнуудын тусгаар тогтнолын нийтлэг ашиг сонирхлыг илэрхийлсэн хүчин зүйлс төлөвшин, нийгмийн байгууллагын онцлогоос хамаарахгүйгээр дайн, түрэмгийллийн эсрэг хамтын үйл ажиллагаа өрнүүлэх замаар түүнд няцаалт өгөх нь чухлыг бүс нутгийн улс орнууд ухамсарлах болов. Түрэмгийлэлд шууд өртөгдсөн Хятад Улс, дайны аюулын өмнө тулгарсан ЗСБНХУ, БНМАУ хийгээд эзлэгдсэн бүх орны ард түмний хүч чармайлтыг нэгтгэх явдал улс төрийн бодлогын түвшинд зүй ёсоор тавигдав.

Зөвлөлт Холбоот Улсын алс дорнодын бодлогод ямагт гол байр эзэлж байсан. Японы аюулын тухай асуудал улам бодитой болж ирсэн энэ үед ЗСБНХУ-ын Засгийн газар өөрийн Алс дорнодын хил хязгаарыг бэхжүүлэх арга хэмжээ авахын зэрэгцээгээр тус бүс нутагт хамтын аюулгүй байдлыг хангах системийг бүрэлдүүлэх, түгшүүртэй байдлыг намжааж тогтворжуулахад нөлөөлж чадах бүх хүчин зүйлийг дайчлахад онцгой анхаарч байжээ. Чухам энэ үүднээс ЗХУ алс дорнодын бодлогодоо БНМАУ-ын тусгаар тогтносон байдлыг хэвээр хадгалж бэхжүүлэх явдалд их ач холбогдол өгч түүнийг өөрийнхөө аюулгүй байдлыг хангах, Ази дахь хүчний

харьцааг тэнцвэржүүлэхэд нөлөөлөх чадвартай хүчин болгож, аль нэг гүрний эрхшээлд оруулахгүй байх нь чухал гэж үзэж байв. Ийм бодлого явуулах үндэс тэр үеийн түүхэн нөхцөлөөр бүрэлдсэн ажээ.

Монголын талаар Япон хамгийн харгис бодлого баримталж Хятадыг бүрэн байлдан дагуулах, ЗХУ-д цөмрөн орох түшиц газар, түүхий эдийн хавсаргаа болгохын тулд түүнийг даруй эзлэн авахыг яаравчилж байв. «Ази азийнхандаа» гэдэг ерөнхий баримтлалын хүрээнд тавигдсан энэ бодлогоо хэрэгжүүлэхийн тулд Япон нь Монголын тусгаар тогтнолыг үгүйсгэх, монголчуудын нэгдэх сонирхлыг ашиглах, нутаг дэвсгэрийн маргаан үүсгэхээс эхлээд цэргийн өдөөн хатгалга үйлдэх хүртэл элдэв арга саам хайх болжээ.

БНМАУ-ын газар зүй, нутаг дэвсгэрийн байрлал, улс төр, стратегийн ач холбогдол хөрш хоёр их гүрний бодлогод хэр бодитой тусгагдсанаас Монголын тусгаар тогтнолын асуудал ихээхэн хамаарч байв. Монголын тусгаар тогтнолын талаар хөрш хоёр их гүрэн-ЗСБНХУ, БНХУ хоёр тус тусын ашиг сонирхол, зорилгоос үүдэн гарсан эрс ялгаатай байр суурь баримталсан ажээ. БНХУ нь Монголыг өөрийн газар нутгийн салшгүй хэсэг хэмээн үзэж, БНМАУ-ын тусгаар тогтнолыг урьдын адил үгүйсгэсээр байв. Ялангуяа Хятадын милитарист хүчин Монголыг өөртөө хүчээр нэгтгэх бодлого баримталж, аятай цаг мөчийг хүлээн байсан билээ. Гэвч Японы түрэмгийлэлд өртөгдөөд байсан Хятад Улсад Монголыг эзлэх санаархлаа хэрэгжүүлэх тэнхэл олдоогүй юм.

БНМАУ-ын тусгаар тогтнолд илүү бодитой, эергээр нөлөөлсөн хүчин зүйл бол ЗСБНХУ-ын бодлого, үйл ажиллагаа байв. ЗХУ хэдийгээр Хятадтай харилцахдаа Монголыг түүний бүрэлдэхүүн хэсэг хэмээн үздэгээ нотолсоор байсан боловч Монголын засгийн газрыг хууль ёсны хэмээн хүлээн зөвшөөрсөн 1921 оны гэрээний үзэл санаа, байр сууриа тууштай хамгаалж, тэнд хятадын улс төрийн нөлөөг үл нэвтрүүлэх, харин өөрийн үзэл суртал, улс төрийн нөлөөг хүчтэй болгох бодлогоо хатуу баримталж байжээ.

Монголын талаар баримтлах Зөвлөлтийн бодлогыг боловсруулж, тодорхойлж хэрэгжүүлэгч гол байгууллага нь Коминтерн ба Гадаад хэргийн ардын комиссариат (ГХАК) байв. БНМАУ-ын тусгаар тогтносон улс хэвээр байлгах нь Зөвлөлт Холбоот Улсад ямар ач холбогдолтой болохыг түүхэн цаг үе ба нөхцөл байдалтай холбоотойгоор тал бүрээр тодорхойлсон нь цөөнгүй. Бүр 1927 оны арванхоёрдугаар сард КИГХ-ны Дорнодын Нарийн бичгийн дарга нарын газрын нэгэн хуралдаан дээр Комицтернии Монгол дахь төлөөлөгчийн илтгэлд нэлээд дэлгэрэнгүй авч үзсэн байдаг. Түүнд өгүүлснээр, БНМАУ бол Төв Азийн үлэмжхэн хэсэгт, гол нь Коминтерний хувьсгалт нөлөө хараахан нэвтэрч амжаагүй байгаа Төвд зэрэг газарт хувьсгалт ажил өрнүүлэх түшиц газар болж буй, ЗХУ болон Японы хооронд, Хятадын милитарист секторууд болон ЗХУ-ын хооронд бамбай улс болж байгаа, энэ үүднээс Монгол улс одоо дайны аюул нөмрөн ирж буйтай уялдан ЗСБНХУ-ын хувьд цэрэг стратегийн ан

холбогдолтой болж буй; бид БНМАУ-ыг хэрэг дээрээ өрнүүн хувьсгалт байгуулалтыг амьдралд хэрэгжүүлэх, ингэснээрээ колонийн асуудлаарх манай программын нэг үндсэн зүйл, зарчмын нэг үндсэн сэдвийг колонийн ба хагас колонийн хоцрогдсон ард түмэн хувийн капиталист хөгжлийн шатыг алгасан социализмд шилжих нийгэм эдийн засгийн өвөрмөц хөгжлийн бололцоонд холбогдох хэсэгт нь баримтлан явуулах ёстой нэг тийм амьд лаборатори, өвөрмөц маягийн төржүүлсэн туршлагын талбай болох, Монголыг өөрийн нэг колони болгож авах санаа бодлоор Монгол руу тэмтрүүлээ шургуулж байгаа нэлээд хэдэн империалист гүрний шуналыг хөдөлгөж буй объект болж буйд оршино. Монголыг их ач холбогдолтойд үзвэл зохио сүүлчийн нэг Учир гэвэл бид Монголыг Хятадын аугаа их хувьсгалын нэг дайчин хүчин гэж үзвэл зохино гэжээ.

Монголыг хөгжүүлэх үндэсний ардчилсан чиг баримтлалыг өөрчилсөн МАХН-ын ҮII их хурлын дараа энэ асуудлыг хэт зүүний чиг хандлагыг тодотгох үүднээс тайлбарласан байдаг. КИГХ-ын ДНБДН Газрын 1929 оны нэгдүгээр сарын 7-ны хуралдаан дээр Б. Шмераль хэлсэн үгэндээ «Бид тэнд олон улсын маш чухал ач холбогдол бүхий өргөн уудам нутаг дэвсгэртэй тулгарч байна. Монголын нутаг дэвсгэр Англи, Герман, Францынхыг нийлүүлснээс өргөн уудам, хүн ам нь дөнгөж 800000 хүн, Бид энэ байдлыг харгалзах ёстой. Энэ нутаг дэвсгэрт нөлөөгөө хадгалж ядахдаа, Монголыг империалистууд хийгээд дэлхийн хувьсгалын дайсны нөлөөнд оруулахгүй байхыг сөрөг аргаар ч болов хичээх нь манай зорилт мөн гэж би хэлж байна, Энэ бол 800000 хүнтэй улс оронд социализм байгуулахаас илүү чухал зорилт, Ангийн зөрчлийг ч шийдвэрлэх хэрэгтэй л дээ, гэхдээ энэ зорилтыг эхний гол зорилттой уялдуулан тавих ёстой, Нутаг дэвсгэр нь хүн амаасаа илүү чухал ач холбогдолтой бөгөөд хэрэв бид энэ цөөхөн хүн амыг капиталист бус хөгжлийн замаар оруулж, Монгол дахь хөдөлгөөнийг хөдөлмөрчин олны ангийн тэмцэл болгож чадвал зөвхөн ийм янзаар л бид энэ нутаг дэвсгэрийг өөрийн нөлөөнд байлгаж чадна»² гэжээ. Иймэрхүү үнэлэлт дүгнэлт нь Монголд явуулах улс төрийн бодлого, үйл ажиллагаанд тусгалаа олсны үр дагавар болсон 1930-аад оны эхээр Монголд явагдсан «зүүний» нугалаа завхрал, түүний уршиг болон өрнөсөн зэвсэгт бослогод хүргэсэн билээ,

Монгол дахь үйл явдлын өрнөлт нь ЗХУын Монголд явуулсан бодлого, түүний Алс Дорнодын нийт бодлогод хор хохирол учруулах аюултай түвшинд хүрлээ гэж Зөвлөлтийн Удирдлага үзжээ. Иймээс түүнийг засаж залруулах ажилд яаравчлан орсон байна, Юуны урьд Монголд явуулах бодлого, үйл ажиллагааг удирдах урьдах хэлбэр нь хоёрдуулах, завсардуулах, зөрчилдөхөд хүргэж байсан гэж үзэн 1932 оны хавраас МАХН-ын Төв Хороонд Коминтерний байнгын төлөөлөгч суулгахыг зогсоож бүх удирдлагыг БХК (б) Намын төлөөлөгч бөгөөд Зөвлөлтийн бүрэн эрхт төлөөлөгчид төвлөрүүлэхээр, шийдвэрлэжээ. Монгол дахь БХК (б) намын

төлөөлөгч бөгөөд Зөвлөлт Холбоот Улсын бүрэн эрхт төлөөлөгч А, Я, Охтинд өгсөн 1932 оны дөрөвдүгээр сарын 23-нд БХК (б) намын Төв Хорооны Улс Төрийн Товчооноос баталсан зааварт өгүүлэхдээ; Монгол дахь манай улс төр, аж ахуйн байгууллагууд, түүнчлэн бүх зөвлөгч, сургагч нарын ажлын ерөнхий удирдлага нь Монголтой харилцах албан ёсны харилцаанд ЗСБНХУ-ын бүрэн эрхт төлөөлөгч болох БХК (б) намын Төв Хорооны төлөөлөгчид тохоогдож байна. Мөн МАХН-ын Төв Хороотой холбоо барьж түүний ажилд тусламж үзүүлэх, бүрэн эрхт төлөөлөгчид туслахын тулд БХК (б) намаас МАХН-ын Төв Хороонд тусгай зөвлөх томилон суулгах бөгөөд тэр нь намын сургагч нарын ажлыг Удирдахын хамт, нөхөр Охтинд бүрэн захирагдаж, түүний заавраар ажиллах туслагч нь байх болно гэж заажээ. Цэргийн болон дотоодыг хамгаалахын гол сургагч нар ажил төрлийн хувьд бүрэн эрхт төлөөлөгчид захирагдахын хамт, түүгээр дамжуулан тэдэнд Удирдамж өгч байдаг ЗСБНХУ-ын холбогдох байгууллагуудтай харилцах эрхтэй гэдгийг бас заан тэмдэглэжээ. Зааврын эцэст Зөвлөлтийн үзүүлж байгаа тусламж хамгийн үр өгөөжтэй ашиглагдаж, Монголын ардын ядуу дунд олон түмний жинхэнэ тусгаар тогтносон төр улсын хувьд БНМАУ дээд зэргээр өсөж бэхжихэд нь дөхөм үзүүлсэн байхуйцаар шаардагдах арга хэмжээ авч ажиллахыг БХК (б) намын төлөөлөгч (бүрэн эрхт төлөөлөгч)-д даалгажээ. Ийнхүү Монголд ЗХУ-ын бодлого, заавар зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг удирдах арга, хэлбэр, механизмд үлэмж төвлөрүүлсэн шинэ тогтолцоо бүрэлдэж эхэлжээ. 1932 оны тавдугаар сарын 16-нд хуралдсан БХК (б) Намын Төв Хорооны Улс Төрийн Товчооны хурлаас Сталины гарын үсэг бүхий тэмдэглэлд даруй авах арга хэмжээ төвлөн боловсруулах комисст үүрэг өгөхдөө; Монголд гарсан алдаа нь Зөвлөлтийн бодлогыг сохроор хуулбарласны үр дагавар, Монголд өрнөж буй бослогын гол шалтгаан болж байгаа бөгөөд энэхүү алдааг арилгахгүй бол, хөрөнгөтний ардчилсан бүгд Найрамдах Улсад зохицсон зөв бодлогод шилжихгүй бол Монголын бүгд Найрамдах Улс оршин тогтнох хэрэгт аюул занал оршсоор байх болно гэдгийг онцлон анхааруулжээ.

КИГХ ба (БХК (б) Намын Төв Хорооны хамтарсан хурлаас 1932 оны тавдугаар сарын 29-нд «Монголын тухай» гаргасан тогтоолд БНМАУ тусгаар тогтносон улсын хувьд оршин тогтнож байх агуулга хэлбэрийг тодорхойлохдоо; «Одоогийн хөгжлийн шатан дээр Бүгд Найрамдах Монгол Ард Улс болбоос өөрийн нийгэм-эдийн засаг ба үндэсний аж байдлын онцлогоос шалтгаалан пагцхүү капиталист бус хөгжлийн замд аажмаар шилжих үндсүүдийг тавьж буй ардын хувьсгалт, империализмын эсрэг шинэ маягийн хөрөнгөтний ардчилсан бүгд Найрамдах Улсын шинжтэйгээр тогтнон байж чадна, Монгол Ардын Хувьсгалт Засгийн үндсэн зорилт болбоос тус бүгд Найрамдах Улсыг тусгаар тогтносон бөгөөд империализмын эсрэг үндэсний төр Улс хэмээн үзэж бэх-

жүүлэх, бүгд найрамдах Улсын үйлдвэрлэх хүчнийг дээд зэргээр хөгжүүлэх, феодализмын үлдэгдлүүдийг үндсээр нь устгах, хөрөнгөтний капиталист мөлжимтгий этгээдийг аажмаар хязгаарлах, гадаадаас халдан орох аюул заналаас Монголыг хамгаалах явдлууд мөн болно» гэжээ.

Монгол дахь «зүүний» алдаа, завхралыг засах, өргөн олныг хамарсан бослого хөдөлгөөнийг дарж амгалан тайван байдал тогтоох, Монголын хөгжлийн чиг бодлогыг үндсээр нь өөрчлөхөд чиглэсэн уг тогтоолын үзэл санааг Монголд хүргэж хэрэгжүүлэх үүрэгтэйгээр 1932 оны тавдугаар сарын эцсээр КИГХ ба БХК (б) намын төлөөлөгч Ш. Элиав хэмээгчийг Монголд ирүүлсэн юм. Тэрээр 1932, 1933 онд Монголд хэд хэдэн удаа ирж ажиллажээ.

Хэрэв урьд Монголын тусгаар тогтнон оршихын ач холбогдлыг үнэлэхдээ ЗХУ дэлхийн хувьсгалыг өрнүүлэн хөгжүүлэх зорилттой ихэвчлэн холбож байсан бол 1930-аад онд Алс Дорнодод үүссэн шинэ нөхцөл байдалд Монголын тусгаар тогтнолын асуудлыг цэрэг стратегийн ач холбогдлын үүднээс үнэлэх тал нь давамгайлах болжээ. 1933 оны аравдугаар сарын 19-нд БХК (б) Намын Төв Хорооноос баталж Ш. Элиавт өгсөн нэгэн Удирдамждаа Япон, Зөвлөлтийн харилцаа түгшүүртэй болж байгааг тэмдэглээд сүүлийн үеийн Японы бодлогын бүх явцаар ч, Японы цэргийн удирдах хариуцлагатай ажилтнуудын удаа дараагийн хэлсэн үгүүдээс ч нотлогдож буй ЗСБНХУ-ын эсрэг дайн хийхийн тулд юуны урьд БНМАУ-ын газар нутгийг эзлэн авахаар бүх талаар бэлтгэн зэхэж, Японы түрэмгийллийн аюул хүчтэй болж байгааг Монголын Удирдлагуудад сайтар тайлбарлан таниулах, Монголын армийн дайчин чадварыг дээшлүүлэх, БНМАУ-ын батлан хамгаалалтыг бэхжүүлэх яаралтай, жинтэй арга хэмжээ авахыг анхааруулсан байна.

БНМАУ-ын тусгаар тогтнолыг хамгаалан бэхжүүлэх, ЗСБНХУ-ын алс дорнодын хил хязгаарын аюулгүй байдлыг хангах асуудлын харилцан хамаарал, хоёр орны эрх ашгийн нийтлэгийг бүх талаар нээн тодруулах үндсэн дээр хоёр орны хамтын ажиллагааг цэрэг, стратегийн хүрээнд нягт уялдуулах явдал Зөвлөлтийн дорно дахины бодлогын тулгамдсан зорилт болов. Хэрэв Алс Дорнодод дайн дэгдэж хүндрэл учирвал Хятадтай харилцах ганц гарц Монгол болох юм гэж үзэж байв, Ер нь Япон Улс Монголыг эзлээд тэнд Зөвлөлтийн эзэмшиж буй шиг тийм нөлөө хүчийг олж чадвал юу болох нь аяндаа тодорхой байв. И. Сталин: Зөвлөлтийн маш чухал стратегийн зангилаан дээр оршдог учраас Гадаад Монгол тусгаар байх хэрэгтэй гэж үзээд «Хэрэв ЗСБНХУ Гадаад Монгол шиг бамбай улсгүй байх юм бол алс дорнодын нутаг дэвсгэрээ хамгаалж чадахгүй» гэж хэлсэн байдаг. ХУ-ын 3000 шахам км хилийн байгалийн хамгаалалт болж байсан, Монголын өргөн уудам нутгаас япончууд Сибирь, Байгалийн чиглэлээр хялбархан нэвтрэн орох болно гэдгийг хатуу ойлгож байсан Зөвлөлтийн тал Алс дорнодод гарч бо-

лох дайныг ЗСБНХУ ба БНМАУ-аас аль болох холдуулахад чиглэсэн бодлого явуулахыг чухалчилжээ. Энэ үүднээс Монголын тусгаар тогтнолыг хэвээр хадгалан бэхжүүлэх нь жилээс жилд Зөвлөлтийн анхаарлыг Улам их татаж байв. Монголын тусгаар тогтнол, батлан хамгаалалтанд шууд холбогдолтой асуудал. Монголд болж буй зарим сөрөг явдал, монголын удирдлагын дотор зөрчил зэрэгтэй танилцах зорилгоор 1934 оны долдугаар сард ЗСБНХУ-ын ГХАК-ийн орлогч Л. М. Караханыг Монголд илгээжээ. Түүний явсан ажлын дүнгийн тухай Монголын комиссын 1934 оны долдугаар сарын 31-ний хурлаар хэлэлцэн тогтоол гаргаж байжээ. Л. М. Карахан ийнхүү явсан тухайгаа Москва дахь АНУ-ын элчин сайдад ярихдаа Японы талд ажилласан Монголын засгийн газрын зарим гишүүн, армийн том офицерууд, дотосдыг хамгаалахын зарим ажилтныг баривчилснаар Монголын Засгийн газар айлтгүй болсон гэж тэмдэглээд Намайг тэнд айлчлах үед Монгол улс Зөвлөлт Холбоот Улсад нэгдэхийг дахин хүссэн, Мэдээж «большевик империализм» гэж нэрлэгдэх үйл ажиллагаагаар энэхүү мөчид зарим орныг айлгахгүйн тулд өмнөх зургаан хүсэлтийг татгалзсаны нэгэн адил ЗХУ энэхүү хүсэлтийг ч татгалзлаа. Монголын одоогийн байдал бидэнд илүү тохиромжтой байна гэжээ.

Монголын хамгийн үнэт зүйл бол үндэсний тусгаар тогтнол, төр ёсоо хамгаалах явдал ямагт байсан, Монгол мэт аливаа хөгжиж дэвжье гэсэн бага жижиг орон заавал том гүрний бодлогын орчил, нөлөөний хүрээнд орох хэрэгтэй болдогийг дэлхийн түүх харуулсан, бас Монголын тусгаар тогтнолд түрэмгийлэн халдах аюул илэрхий болсон тухайн нөхцөлд Монголын хувьд ЗХУ-тай адилтгах, тэнцэх холбоотон байхгүй гэдгийг монголын ард түмэн, түүний Засгийн газар ойлгож байв, Зөвлөлт Холбоот Улсын бодлого дэмжлэгээс Монголын тусгаар тогтнол Улам их Хамаарах болж байсан үед 1934 оны аравдугаар сард ЗСБНХУ-тай эдийн засаг, соёлын хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэх, БНМАУ-ын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг сахин хамгаалах зэрэг тулгамдсан асуудлаар хэлэлцээр хийх ерөнхий сайд П. Гэндэн тэргүүтэй төлөөлөгчдийг томилон илгээжээ. 1934 оны арван нэгдүгээр сарын 27-нд БНМАУ, ЗСБНХУ хоорондоо аман хэлэлцээр байгуулж «хэрэв БНМАУ, ЗСБНХУ-д ямар нэгэн гуравдагч этгээд халдан довтолбол бие биедээ тусламж үзүүлэх ба дайсны довтолох аюулыг хамтран сэрэмжлэн зайлуулах» болно гэж тохиролцжээ.

Монгол Зөвлөлтийн удирдагчдын хооронд явагдсан ярилцлагын үеэр Монголын тусгаар тогтнолын асуудал ЗХУ-ын гадаад бодлого, ялангуяа алс дорнодын бодлогод ямар байр эзэлж байгааг нэлээд дэлгэрэнгүй авч үзжээ. Монголын тусгаар тогтнолын асуудлыг хэрхэн үнэлж байгаагаа тодорхойлж И. Сталин хэлэхдээ: «Танай улсын албан ёсоор тогтнох явдал нь та нараас олон улсын баталгааг олж авсан цагт сая болно. Хэрэв тийм баталгааг та нар олж чадах ахуй ер түүнд тэмүү юм үгүй болой, Юуны урьд Хятадаас тусгаар

тогтносон хэмээхийг зарлуулах нь та нарт хэрэгтэй болой, Жич Хятадын зүгээс өөрийн тусгаар тогтносныг батлуулан авч чараад мөн бусад улсээс нэгэн адил батлуулан авч чадвал та нар нь Баруун, Цахар хийгээд бусад Монголын мужуудын дотоод монголчуудыг татах төв болж чадах бөгөөд тэдгээр нь Монголын жинхэнэ тусгаар тогтносон явдал танайд байна гэдгийг мэдэх болно» гэж онцлон тэмдэглэжээ, Энд Монголын тусгаар тогтнолыг дэмжсэн бодлого тов тодорхой илэрхийлэгдсэн боловч тэр үеийн нөхцөлд зөвхөн хоёр улсын хоорондын харилцааны маш нууцлагдсан баримт бичигт тусгагдан үлдсэн юм. Уг баримт бичгийг дэлгэрэнгүйгээр нь энэхүү эмхэтгэлд хавсарган хэвлэснээс үзмүү.

1934 онд Японы цэргийнхэн Монголын эсрэг гол төлөв татнан турших ажиллагаа явуулж байсан бол 1935 оны эхнээс БНМАУ-ын хил хязгаарт цэрэг зэвсгийн хүчээр халдах, өдөөн хатгах явдал ихсэв. 1935 оны нэгдүгээр сарын эцсээр Япон-Манж-го гийн цэрэг БНМАУ-ын хил дээр зэвсэгт түрэмгийлэл үйлдэж тус Улсын нутаг дэвсгэрийн салшгүй хэсэг болсон Халхын сүм, түүний орчим газрыг эзлэн авчээ, Байдлыг хурцатгахгүйн тул Монголын тал ЗХУ-тай зөвшилцөн 1935 оны зургадугаар сарын 3-нд Монгол ба Манж-го-Японы хилийн хэлэлцээр эхэлсэн боловч Японы талын шаардлагаас болж тодорхой үр дүнд хүрээгүй билээ.

ЗХУ-ын Засгийн газар 1935 оны долдугаар сарын 6-нд Токио дахь өөрийн бүрэн эрхт төлөөлөгч К, К, Юренивээр дамжуулан Японы Гадаад явдлын язманд өгсөн мэдэгдэлд; «Монгол, Манж-го-гийг хил дээр болж буй явдал болон Манжуур өртөөнд хэлэлцээ явагдаж тэдгээрт Квантуны армийн командлал идэвхитэй оролцож байгааг Зөвлөлт Засгийн газар анхааралтай ажиглаж байна. Өөрийн хил хязгаарыг хамгаалах үүднээс Гадаад Монголын нутаг дэвсгэрийн халдашгүй байдлыг сонирхож байдаг Зөвлөлт Засгийн газар Япон-Манж-го-гийг цэргийн үйл ажиллагаа нь Япон, Зөвлөлтийн харилцааг хурцатгахад хүргэж болзошгүй гэж сэтгэл ихэд түгшиж байна» гэж тэмдэглээд «Японы засгийн газар хилийн тайван байдал, ёс журам хангах заалтыг Квантуны армийн командалд өгнө гэж» итгэж байгаагаа илэрхийлжээ, ЗСБНХУ-ын ГХАК-ын орлогч Б. С. Стомоняковаас БНМАУ-д суугаа бүрэн эрхт төлөөлөгч В, Х, Таировт мөн сарын 8-нд ирүүлсэн цахилгаан Утсандаа уг мэдэгдлийг бүрэн эхээр нь дурдаад үүнийг Монголын удирдлагад мэдээлбэл зохино⁹ гэжээ. ЗХУ-ын энэхүү байр суурийг Монголын Засгийн газар гүн талархалтай хүлээн авч өндрөөр үнэлж байгааг ерөнхий сайд П, Гэндэнгээс мөн сарын 9-ний өдөр Зөвлөлтийн засгийн газарт илгээсэн захидалд илэрхийлсэн байдлаар.

Япон-Манж-го-гийг талаас Монголын эсрэг, Монгол ба ЗХУ-ын найрамдалт харилцааны эсрэг элдэв гүтгэлэг, суртал нэвтрүүлэг явуулахын зэрэгцээ хилийн будлиан өдөөн хатгах ажил явууллагаа идэвхжүүлж байдлыг Улам ноцтой болгон даамжруулж байв. Энэ талаар тэр үед Харбинд хэвлэг-

дэж байсан оросын цагаантны «Цаг» хэмээх сонинд гүтгэлэгийн болон өдөөн хатгасан материал цөөнгүй гарах болжээ, Монголын дорнод хилийн байдал улам түгшүүртэй тал руу өөрчлөгдөж байсан учир 1935 оны арван нэгдүгээр сарын 17-нд П. Гэндэнгээс И. Сталинд бичсэн захидалдаа Японы түэрмгийллийн аюул, түүнтэй холбогдсон бэрхшээл нэмэгдсээр буйг харгалзан «Манай бүгд найрамдах улсын тусгаар тогтнолыг бэхжүүлэх хэрэгт аливаа тусламж (зохион байгуулалт, техник, санхүүгийн) үзүүлнэ гэдэгт итгэж байгаагаа» илэрхийлжээ, Энэхүү захидалд Уг тусламжийг гуйхдаа би олон тооны цэрэг ирүүлэх гээгүй гол нь техникийн тусламжийн тухай өгүүлж байгаа юм гэж дурдаад зөвхөн дэлхийн хувьсгалын буюу ангиудын хоорондын харилцааны үзэл санааны үүднээс төдийгүй, бас Монголын үндэсний тусгаар тогтнолын өөрийн эрх ашгийн үүднээс ч бидний хувьд Зөвлөлт Холбоот Улсаас өөр хань нөхөр үгүй гэдэгт миний хатуу бодол оршиж байна гэж онцлон тэмдэглэжээ.

ЗХУ-аас Монголын батлан хамгаалах хэрэгт тусламж үзүүлэх асуудлыг 1935 оны эцсээр ерөнхий сайд П. Гэндэн тэргүүлэн ерөнхий сайдын орлогч бөгөөд цэргийн яамны сайд, бүх цэргийн жанжин Г. Дэמיד, Дотоодыг хамгаалах газрын дарга Д. Намсрай нар бүрэлдэхүүнд нь оролцсон БНМАУ-ын Засгийн газрын төлөөлөгчид айлчлах үеэр албан ёсоор тавьсан байна. И. Сталин, Б. Молотов, К. Ворошилов зэрэг Зөвлөлтийн удирдагчидтай хэд хэдэн удаа Уулзаж ярилцахдаа В, Гэндэн, Д, Намсрай нар ЗХУ-аас материал техникийн болон мэргэжилтний тусламж авах хүсэлтэйгээ илэрхийлж цэрэг оруулах асуудал хөндөөгүй ажээ. Харин Г. Дэמיד гадаадын түрэмгийлэгчид довтолбол БНМАУ хүч мөхөсдөх тул Зөвлөлтийн цэрэг, зэвсгийн тусламж авах хэрэгтэй гэсэн байр суурьтай байв, Эдгээр уулзалтын үеэр Зөвлөлтийн Удирдагчдын зүгээс «хэрэв та нар гадагшаа япончуудтай, дотогшоо лам нартай тэмцэхгүй л юм бол манай тусламж ямар хэрэгтэй юм: «Батлан хамгаалахад зориулж буй төсвийн хөрөнгө багадаж байна», «Нөхөр Гэндэн өөрийн орныг батлан хамгаалахад сонирхохгүй байна» гэх мэтээр зэмлээд Монголын төлөөлөгчдийн санал зөрөлдөөнтэй байгаа учир тусламжийн асуудлыг саналаа нэгтгэж байж дахин тавих нь зүйтэй хэмээн буцаажээ.

1936 оны нэгдүгээр сарын 23-нд МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчдийн хурлаас Г. Дэмидийн байр суурийг дэмжээд Зөвлөлтийн цэрэг, зэвсгийн тусламж яаралтай авах асуудлыг ЗХУ-д тавихыг тэргүүлэгч гишүүн А. Амар, П. Гэндэн нарт даалгасны дагуу мөн сарын 25-нд БНМАУ-ын Бага Хурлын тэргүүлэгчид ба Сайд нарын Зөвлөлийн хамтарсан хурлаас цэргийн тусламж авах шийдвэр гаргаж, юуны урьд хоёр мотобригад, нэг нисэх эскадриль аль болох хурдан ирүүлэх хүсэлтийг ЗХУ-д тавьжээ. Энэ хүсэлтийг Зөвлөлтийн Засгийн газар хүлээн авч дэмжихээр болсныг хоёрдугаар сарын 1-нд хариу мэдэгдсэн юм.

Зөвлөлтийн Алс дорнодын бодлогод Монголын асуудал Урьд Урьдаас чухлаар тавигдах болсныг 1936 оны гуравду-

паар сарын 1-нд Америкийн сурвалжлагч Рой Говардтай Зөвлөл-Засгийн тэргүүн И. В. Сталины хийсэн ярилцлага тодорхой харуулсан билээ. «Хэрэв Япон БНМАУ-ын тусгаар тогтнолд халдан довтолох аваас бид БНМАУ-д туслах болно, Бид БНМАУ-д 1921 онд тусалсан шигээ тусална»¹² гэж тэрээр мэдэгджээ. Энэ мэдэгдэл нь Монголд цэрэг, зэвсгийн хүчээр туслахыг хүссэн БНМАУ-ын сонирхолд бүрэн нийцсэн бөгөөд аливаа түрэмгийлэлд өртөгдвөл Монгол улс ганцаардахгүй гэдгийг дэлхий нийтэд сонордуулсан юм.

Зөвлөлт, Монголын цэрэг улс төрийн харилцаа, хамтын ажиллагааг эрх зүйн үүднээс баталгаажуулахад 1936 оны гуравдугаар сарын 12-нд Улаанбаатар хотноо байгуулсан «БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд харилцан туслалцах тухай Протокол» чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. Энэхүү баримт бичигт БНМАУ буюу ЗСБНХУ-ын хязгаар нутгийг гурав дахь улсын зүгээс довтолох занал аюулууд тохиолдвол хоёр Засгийн газар тохиолдсон байдлыг хамт даруй хэлэлцэж тус хоёр улсын нутаг хязгаарыг тэрхүү занал аюулаас хамгаалах явдалд хэрэглэгдэх арга хэмжээнүүдийг авах үүргийг тус тусдаа хүлээнэ», «Энэ гэрээг тогтоосон нэгэн этгээдийг цэргийн хүчээр довтолбол бие биедээ элдэв тусламж, мөн цэрэг, зэвсгийн тусламж үзүүлэх үүрэг хүлээнэ» гэж заагаад уул үүргээ гүйцэтгэсний дараа тухайн цэргийг татан гаргах болно гэдгийг ч гэрээнд дурджээ.¹³ Протоколын агуулга, үзэл санаа, зорилго нь Алс дорнодод энх тайван, аюулгүй байдлыг сахих эрх ашигт нийцэж байсан хэдий ч тэр нь нэн түрүүнд БНМАУ-ын тусгаар тогтнолыг бататган бэхжүүлэхэд шууд чиглэсэн нь илэрхий байсан Учир монголыг өөрийн бүрэлдэхүүн хэсэг гэж зүтгэсээр ирсэн Хятадын засгийн газрын эсэргүүцлийг төрүүлжээ. 1936 оны дөрөвдүээр сарын 6-нд Хятадын Гадаад яамны сайд Жан Цюнь Бээжин дэх Зөвлөлтийн элчин Д. В. Богомолот өгсөн нотод; «Гадаад Монгол бол Бүгд Найрамдах Хятад Улсын салшгүй хэсэг мөн учир гадаадын ямар ч улс түүнтэй ямар нэгэн хэлэлцээр байгуулж үл болно, Хятадын Засгийн газрын хувьд хүлээсэн үүргээ зөрчин Гадаад Монголтой дээрх Протокол байгуулсан, Зөвлөлт Холбоот Улсын Засгийн газрын энэ үйл ажиллагаа нь Хятадын бүрэн эрх болон 1924 оны Хятад-Зөвлөлтийн гэрээний заалтыг зөрчсөн явдал даруй мөн. Иймд Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Протоколыг ямарч нөхцөлд үл зөвшөөрөх бөгөөд түүнд огтхон холбогдолгүй гэж үзнэ»¹⁴ гэдгийг засгийн газартаа уламжлалыг хүсчээ.

Энэ талаар Зөвлөлтийн байр суурийг тодорхойлж ЗСБНХУ-ын Гадаад хэргийн ардын комиссариат М. М. Литвиноваас ЗСБНХУ дахь Хятадын хэргийг түр хамаарагч У Нань Жуд гардуулсан нотод: Протокол байгуулсан явдал болон түүнд заасан зүйлүүд нь Хятадын бүрэн эрхийг өчүүхэн ч зөрчөөгүйгээс гадна Хятад буюу БНМАУ-ын хувьд нутаг

дэвсгэрийн ямар нэгэн шаардлага тавиагүй ба агуулаагүй болно, Протокол байгуулснаар ЗСБНХУ ба Хятад, ЗСБНХУ ба БНМАУ-ын Хооронд өнөө хүртэл тогтож ирсэн албан ёсны ба бодит харилцаанд ямар ч өөрчлөлт оруулаагүй болно. ЗСБНХУ нь харилцан туслалцах Протокол байгуулахдаа 1924 онд Бээжинд гарын үсэг зурсан Зөвлөлт-Хятадын хэлэлцээр огтхон ч үл хөндөгдөн хүчин төгөлдөр байна гэдгээс үндэслэсэн юм. ЗСБНХУ-ын хувьд тэрхүү хэлэлцээр цаашид ч хүчинтэй байна гэдгийг дашрамд Зөвлөлт Засгийн газар дахин нотолж байна. Үүнийг хэлж Зөвлөлт-Монголын хэлэлцээр нь гагцхүү ЗСБНХУ буюу БНМАУ түрэмгийлэлд өртөж өөрсдийн нутаг дэвсгэрийг өмгөөлөн хамгаалахад хүрэх нөхцөлд хэрэгжих учир гуравдахь орны ашиг сонирхлын эсрэг ханддаггүй болно. Дээр дурдсаныг үндэслэн Зөвлөлт Засгийн газар Хятадын Засгийн газрын эсэргүүцлийг үндэсгүй гэж үзэн няцаахад хүрэв, Үүнийг хамт Бүгд Найрамдах Хятад Улсын засгийн газар Зөвлөлт-Монголын протокол Бээжингийн хэлэлцээрт харшлаагүй бөгөөд Монголын ч, хятадын ч ард түмний эрх ашигт нийцэж буйд үнэмшинэ гэдэгт гүнээ итгэж байгаагаа илэрхийлэв гэжээ. Үүнийг зарим судлаачдын тайлбарладгаар «Монголыг Хятадын бүрэлдэхүүн хэсэг гэж ЗХУ үзсээр байгааг нотолсон» гэхээсээ Монголын тусгаар тогтнол Улам бодитой болж байгааг тусгасан гэлтэй.

Японы Засгийн газар 1933 онд Лиги-нациас гарснаа зарлаж, Хятад болон Азийн дорнод хэсэг- түрэмгийллээ өргөжүүлж, 1936 оны эцсээр «Коминтерний эсрэг гэрээнд» үсэг зурж, Монгол, Зөвлөлтийн эсрэг цэргийн өдөөн хатгалгах үйлдэн, дайнд шаргуу бэлтгэж ялангуяа 1938 оноос дотооддоо цэргийн фашист дэглэм тогтоох, эдийн засгийг милитарчлах зэргээс Алс дорнодод дайны аюул бодитой болсныг харгалзан үзвэл Монгол-Зөвлөлтийн харилцан туслалцах тухай Протокол олон Улсын ач холбогдолтой юм,

Дэлхий дахиныг фашизм, дайны аюул нөмөрч, түүний эсрэг бүх хүч хэрэгслийг дайчлах, дайны эсрэг улс, орон бүрийн хүч чармайлтыг нэгтгэх шаардлага өссөөр байгааг олон Улсын бодлогынхоо гол шалгуур гэж үзэх чиглэл Зөвлөлтийн бодлогод томоохон байр эзэлж цэрэг-стратегийн тал нь Улам давамгайлах болжээ. Зөвлөлтийн Удирдлага гадаад улс төрийн бодлогодоо цэрэг стратегийн хүчин зүйлийн ач холбогдлыг өндөрт тавьсан нь түүний Алс Дорнодын түүний дотор Монголын тусгаар тогтнолын талаарх бодлогод бодит тусгалаг олсон ажээ. Тэгээд ч Монголын тусгаар тогтнолыг хамгаалах асуудалд ЗХУ энэ үүднээс хандаж цэрэг засгийн тусламж хүссэн монголын засгийн газрын хүсэлтийг тэр даруй бүрэн дүүрэн дэмжиж, 1937 онд Зөвлөлтийн цэргийн ангиудыг Монголд ирүүлэн Монголын ардын армид эжиллэх цэргийн зөвлөх, сургагч мэргэжилтнүүдийн тоог ч нэмэгдүүлж цэргийн дайчин чадварыг дээшлүүлэх, шинэхэн техник эзэмшүүлэхэд яаравчлан туслаж байв, Цэрэг, мэргэжилтэн ирүүлэх, Монголд байх хугацааныг бүх зардлыг Зөвлөлтийн тал өөрөө хариуцжээ.

ЗХУ-ын алс дорнодын бодлого тухайлбал БНМАУ-ын тусгаар тогтнолын талаарх чиг баримтлалыг хэрэгжүүлэхэд хувьсгалын эсэргүүчүүд, гадаадын тагнуулыг илчлэн устгах, ангийн дайсантай тэмцэх нэрийн дор өрнүүлсэн улс төрийн хэлмэгдүүлэлт хүндээр нэрэвсэн билээ, Энэ нь нэг талаар дайны аюул, олон улсын түгшүүртэй байдал хүчтэй болсны улмаас гадаадаас тагнаан турших, өдөөн хатгах явдал ихсэж, улс төрийн хардалт, сэрдэлт, үл итгэх байдал дэлгэрсэнтэй холбоотой, нөгөө талаар Сталины бүхнийг шийдэгч бодлогыг дуулгавартайгаар үл дагагсадыг замаас зайлуулах зорилтыг тусгасан юугаар ч зөвтгөгдөшгүй туйлын эмгэнэлт хэрэг байлаа, 1930-аад оны хувьсгалын эсэргүү, гадаадын тагнуул хэмээгдсэн Улс төрийн хилс хэрэгт монголын төр, засаг, нам, олон нийтийн байгууллагын удирдах ажилтнууд, цэргийн албан хаагчид соёлын зүтгэлтэн, үндэсний сэхээтний бүхэл үеийнхэн лам хувраг, жирийн хөдөлмөрчдийг үй олноор хэлмэгдүүлсэн Урьд хожид дулдаагүй бурангуй хэрэг үйлдэгдсэн байна, Монголын удирдагчдыг томилох, халахаас эхлээд баривчлах хорих, Зөвлөлтийн нутагт цөлөх, зөвлөлтийн хуулиар цээрлүүлэн шийтгэх, цаазлан хороох хүртэл Монголын дотоод хэрэгт Сталин болон түүний гар хөл бологчид шууд оролцдог болжээ, Энэ бүхэн монголын тусгаар тогтносон байдалд ноцтой хохирол учруулаад зогсоогүй, Монгол-Зөвлөлтийн харилцааны мөн чанарыг гүйвуулан гажуудуулж, олон улсын харилцааны эрх зүйн хэм хэмжээ, тэгш эрх, харилцан хүндэтгэх зарчмыг хөсөрдүүлэхэд хүргэсэн юм.

Алс Дорнод дахь их гүрнүүдийн өрсөлдөөнд Хятад, Японыг үл нэгдүүлэх Зөвлөлтийн бодлого, Япон Зөвлөлтийг мөргөлдүүлэх Хятадын бодлого, Хятад, Зөвлөлтийг тусгаарлан холдуулах Японы бодлого тодорч ирсэн тэр үед Монголын тусгаар тогтнолын асуудалд бодитой хандаж Монголын ард түмний хүсэл зоригийг дэмжсэн Улс л өөртөө давуу байдал олж авах тийм стратегийн зангилсан дээр БНМАУ оршиж байсан билээ. Иймээс монголын асуудал их гүрнүүдийн бодлогын «тоглоомын хөзөр» болж ирсэн хэмээх нь хэтэрхий өрөөсгөл, хөнгөн хуумгай дүгнэлт бололтой. Харин ч БНМАУ-ын байр суурь, түүхэн үүрэг, улс төр, стратегийн ач холбогдлыг харгалзан үзвээс зохилтойг 1939 оны Халх голын байлдаанд Японы түрэмгийлэгчдийн эсрэг Монгол, Зөвлөлтийн цэргийн байгуулсан ялалт нотлон харуулсан юм.

Халх голын ялалт нь БНМАУ-ын газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, түүний тусгаар тогтнолыг баталгаажуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн төдийгүй Улмаар японы түрэмгийллийг эсэргүүцсэн бусад Улс түмний тэмцэлд ч ялах итгэл төрүүлж Алс Дорнодод түгшүүртэй байдлыг намжаахад таатай нөлөөлснийг тэмдэглэвээс зохино.

1930-аад оны үеийн Монголын орчин тойронд өрнөсөн үйл явдлууд, Зөвлөлтийн алс дорнодын бодлогоор дэвшиг-

дэж хэрэгжсэн улс хоорондын харилцааны эерэг, сөрөг үр дагаврууд Монгол ба Зүүн хойт Азийн орнуудын сонирхлын хүрээ, эрх ашгийн нийтлэг бүрэлдэх тус бүс нутгийн Улс хоорондын харилцааны эерэг тал, харилцан хамаарал улам тодорч энх тайван, хамтын ажиллагааны боломжууд нээгдэхэд зохих түлхэц өгчээ,

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. РЦХИДНИ (Россиский центр хранения и изучения документов новейшей истории-Шинэхэн түүхийн баримтууд, хадгалах судлах Оросын төв) Ф. 495, ОП. 154, д, 283, Л, 60-61,
2. «Коминтерн ба Монгол» (Баримтын эмхэтгэл) УБ, 1996, 284-285 дахь тал,
3. РЦХИДНИ ф. 17, оп. 162, д, 12, Л-111,
4. РЦХИДНИ ф. 17, оп. 162, д, 12, Л 137,
5. «Коминтерн ба Монгол» (Баримтын эмхэтгэл) 393—394 дэх тал.
7. «Дорно дахины судлалын асуудал» сэтгүүл, 1989, № 2 (21) 21 дэх тал,
8. «Засгийн газрын мэдээ» сонин, 1995. 8.31, № 111-112
9. «Документы внешней политики СССР» т. ХVIII. М. 1973, с, 445,
10. Мөн тэнд
11. МАХН-ын Төв архив, ф. 1. Т, 5, хн. 108, х. 167.
12. «Документы внешней политики СССР» т. XIX М, 1974, с, 105,
13. «Монгол-Зөвлөлтийн харилцаа», 1 дэвтэр, 1920-1940, УБ. 1976. 395 дахь тал,
14. Мөн тэнд 397 дахь тал.
15. Мөн тэнд 398-399 дэх тал.